



БАЯНХОНГОР АЙМАГ  
БААЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 4/33

Баянсайр

Баянхонгор сумын Засаг дарга  
Г.Энхбаярын нэрэмжит "Сорил-2"  
шалгалт зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Боловсролын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.13, Баянхонгор сумын Засаг дарга Г.Энхбаярын нэрэмжит "Сорил-2" шалгалтын тухай удирдамжийн "Зохион байгуулалт"-ын 1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Аймгийн хэмжээнд 2021-2022 оны хичээлийн жилд 12 дугаар анги төгсөж буй сурагчдыг элсэлтийн ерөнхий шалгалтанд бэлтгэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, зөвлөн туслах, амжилт гаргасан багш, сурагчдыг урамшуулах зорилгоор Баянхонгор сумын Засаг дарга Г.Энхбаярын нэрэмжит "Сорил-2" шалгалтыг 2022 оны 03 дугаар сарын 26-ны өдөр зохион байгуулсугай.

2. "Сорил-2" шалгалтын комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Шалгалтын комиссын дарга: Б.Наранбаатар (Засаг даргын Тамгын

газрын дарга)

Гишүүд: О.Дашдаваа (Бэлчээр, газар тариалан, хоршооны

мэргэжилтэн)

Ж.Оргилмаа (Улсын бүртгэгч)

Г.Энхжаргал (Хууль эрх зүйн мэргэжилтэн)

Ж.Болорцэцэг (Математикийн багш)

П.Дуламжав (Монгол Хэл, уран зохиолын багш)

Нарийн бичгийн дарга: Ш.Баянзул (Сургалтын менежер)

642101333

3. Нэрэмжит "Сорил-2" шалгалтыг хугацаанд нь хуваарийн дагуу чанартай зохион байгуулж, шалгалтын хариултын хуудсыг шалгалтын товч тэмдэглэлийн хамт битүүмжлэн аймгийн Боловсрол Шинжлэх ухааны газарт хүргүүлэхийг шалгалтын комиссын дарга (Б.Наранбаатар)-т даалгасугай.

4. Захирамжийн биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Бямбаням)-д даалгасугай.

ДАРГА  С.ЭНХТӨР

